



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

САЙНЦАГААН СУМЫН МАТЕМАТИКИЙН
ГҮНЗГИЙРҮҮЛСЭН СУРГАЛТТАЙ
ДӨРӨВДҮГЭЭР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ОДОНЧИМЭГ ТАНАА

2017.01.16 № 01/01

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Сайнцагаан сумын Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай дөрөвдүгээр сургуулийн 2016 оны гуравдугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар нягтлан бодогч нь ээлжийн амралттай байх хугацаанд цалин давхардуулан **253,288.00** /Хоёр зуун тавин гурван мянга хоёр зуун наян найман/ төгрөгийг илүү тооцож олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/-т, мөн 16 дугаар зүйлийн 16.5.3 /батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох/-т заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий Аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.3-д /Бусад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон/ гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. **Давхардуулан олгосон 253,288.00** /Хоёр зуун тавин гурван мянга хоёр зуун наян найман/ төгрөгийг нягтлан бодогчоор нөхөн төлүүлж, Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 080000955 дугаар дансанд 2017 оны 02 дугаар сарын 10-ны дотор төвлөрүүлэх,

Актын биелэлтийг 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор Аудитын газарт ирүүлэхийг Сайнцагаан сумын Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай дөрөвдүгээр сургуулийн захирал /С.Одончимэг/, нягтлан бодогч /П.Мөнгөнцэцэг/ нарт хариуцуулав.



ТОГТООСОН¹:

Аудитор  /Т.Оюун-Эрдэнэ/



АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:

Захирал:  /С.Одончимэг/
Нягтлан бодогч:  /П.Мөнгөнцэцэг/

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.